

## **“ТӨРИЙН АЛБАН ТУШААЛД ТУРШИЛТЫН ХУГАЦАА ХЭРЭГЛЭХ БОЛЗОЛ, ЖУРАМ”**

### **Нэг.Нийтлэг үндэслэл**

1.1.Төрийн албан тушаалд мэдлэг, боловсрол, мэргэжил, мэргэшил, ур чадвартай иргэнийг төрийн албанд анх томилоход туршилтын хугацаа тогтоож, хэрэглэхэд энэхүү журмыг мөрдөнө.

1.2.Төрийн албан тушаалд туршилтын хугацааг хэрэглэхэд Төрийн албаны тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан зарчмыг баримтална.

### **Хоёр. Төрийн албан тушаалд туршилтын хугацаа хэрэглэх болзол, журам**

2.1.Төрийн жинхэнэ албан тушаалд анх орсон, төрийн жинхэнэ албаны ерөнхий шалгалтад тэнцсэн, туршилтаар томилогдох албан тушаалын шаардлагыг хангасан иргэнд туршилтын хугацааг 6-12 сар хүртэл хугацаагаар тогтооно.

2.2.Төрийн үйлчилгээний албан тушаалд туршилтын хугацааг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу хэрэглэнэ.

2.3.Туршилтын хугацааг шийдвэрээр сунгаж болох бөгөөд туршилтын нийт хугацаа энэ журмын 2.1, 2.2-т заасан хугацаанаас хэтэрч болохгүй.

2.4.Туршилтын хугацаанд ажиллаж байгаа төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэл, үр дүнг холбогдох журмын дагуу үнэлж, дүгнэнэ.

### **Гурав. Туршилтын хугацаанд ажилласан төрийн албан хаагчийг төрийн албан тушаалд томилох, чөлөөлөх**

3.1.Туршилтын хугацаанд дараах болзлыг хангаж төрийн албанд цаашид үр бүтээлтэй ажиллаж чадахаа нотлон харуулсан төрийн албан хаагчийг томилох эрх бүхий этгээдийн шийдвэрээр тухайн албан тушаалд томилно.

3.1.1.албан тушаалын тодорхойлолтод заасан чиг үүргээ хангалттай сайн биелүүлсэн;

3.1.2.төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг сахиж ажилласан;

3.1.3.шаардлагатай мэргэшүүлэх багц сургалтанд хамрагдсан.

3.2.Энэ журмын 3.1-д заасны дагуу төрийн жинхэнэ албан тушаалд томилогдсон албан хаагчийг холбогдох журмын дагуу тангараг өргүүлнэ.

3.3.Туршилтын хугацаанд энэ журмын 3.1-д заасан болзлыг хангаагүй иргэнийг төрийн албан тушаалд томилохгүй.

3.4.Төрийн албан тушаалд ажиллах чадваргүй нь туршилтын хугацаа дуусахаас өмнө мэдэгдэж, улмаар цаашид үргэлжлүүлэн ажиллуулах нь тухайн байгууллагын үйл ажиллагаанд сөрөг нөлөө үзүүлэхээр бол түүнийг томилох эрх бүхий этгээдийн шийдвэрээр туршилтын хугацаа дуусахаас өмнө албан тушаалаас нь чөлөөлж болно.

3.5.Энэ журмын 3.4-д заасан үндэслэлээр чөлөөлөгдсөн иргэн төрийн жинхэнэ албан тушаалд анх орох иргэний нөөцөд байгаад тооцогдоно.

3.6.Төрийн албанд өмнө нь ажиллаж байсан боловсрол, мэдлэг, мэргэшил, туршлага, сахилгын шийтгэлээр төрийн албанаас халагдаж байгаагүй, ял шийтгэл эдэлж байгаагүй иргэнийг дахин төрийн жинхэнэ албан тушаалд томилох тохиолдолд энэ журамд заасан туршилтын хугацаа хамаарахгүй.

### **Дөрөв. Туршилтын хугацааны цалин хөлс**

4.1.Төрийн жинхэнэ албан тушаалд туршилтын хугацаагаар ажиллаж буй иргэнд тухайн албан тушаалын цалин хөлсийг олгоно.

4.2.Төрийн үйлчилгээний албан тушаалд туршилтын хугацаагаар ажиллаж буй иргэний цалин хөлсийг Хөдөлмөрийн тухай хуульд заасны дагуу олгоно.

### **Тав. Бусад**

5.1.Туршилтаар ажилласан хугацааг төрийн алба хаасан хугацаанд оруулан тооцно.

5.2.Иргэнийг төрийн албан тушаалд анх томилохдоо энэ журмыг баримтлаагүй томилох эрх бүхий этгээдэд Төрийн албаны тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан хариуцлага хүлээлгэнэ.

5.3.Туршилтын хугацаанд ажиллаж байгаа иргэнийг өөр ажил, албан тушаалд шилжүүлж, сэлгэн ажиллуулахгүй.

----oOo----